FLASH audit

АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

OBJECTIVE

Бид чанарыг эрхэмлэнэ

ADDRESS
Улаанбаатар хот
Elizabeth хотхон

PHONE
99138333

EMAIL
flashaudit1@gamil.com

WEBSITE
http://audit.monicpa.mn/?company=Flash%20Audit&page_id=3

FLASH AUDIT
ТАНЫ БИЗНЕС ТАНЫ ГАРТ
ЭФ ЭЛ ЭЙ ЭС ЭЙЧ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-дугаар хороо
Элизабет хотхон 215-дугаар байр, 604 тоот
И-мэйл: flashaudit1@gmail.com, Утас: 99138333
Огноо 23.03.30 № ГА-29-47
Танай_____№_____

"ХАС ХААН ББСБ"ХХК-ийн
УДИРДЛАГАД
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид "ХАС ХААН ББСБ" ХХК-н 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар "ХАС ХААН ББСБ"ХХК-н 2022 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү аудитын ажлыг бид Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт тусгав. Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу бид компаниас хараат бусаар НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэдэгт итгэж байна.

Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан болон аудитын тайланд ороогүй мэдээллээс бүрдэнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

"ФЛАШ АУДИТ" ХХК
№ 1

Удирдлага Болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээн бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залилан гэдэгт хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус, харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилд хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн

компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдтэй харилцдаг.

Бусад

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох "ХАС ХААН ББСБ" ХХК-н хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

"ЭФ ЭЛ ЭЙ ЭС ЭЙЧ АУДИТ" ХХК

Хаяг: УБ, БЗД, 26-хороо Элизабет хотохон 215-дугаар байр 604 тоот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ж.ОТГОНЦЭЦЭГ /

ОГНОО: 2024/05/30

FLASH AUDIT LLC ЭФ ЭЛ ЭЙ ЭС ЭЙЧ АУДИТ ХХК FLASH 5735214 УЛААНБААТАР ХОТ

"ФЛАШ АУДИТ" ХХК

2022 ОНЫ АУДИТАЛСАН САНХҮҮ БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

"Хас хаан ББСБ" ХХК — 2022 оны 12 сарын 31

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	Санхүүгийн тайлангийн дүн 2022.12.31	Аудит хийгдсэн дүн 2022.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,029,280,100.06	1,029,280,100.06
Нийт зээл	17,512,763,174.05	17,512,763,174.05
(Зээлийн эрсдэлийн сан)	(3,724,633,893.79)	(3,724,633,893.79)
Факторингийн тооцооны авлага /цэврээр/	1,322,451,030.96	1,322,451,030.96
Бусад авлага	586,341,260.14	586,341,260.14
Бусад хөрөнгө	997,528,953.03	997,528,953.03
Үндсэн хөрөнгө	366,658,779.16	366,658,779.16
Нийт хөрөнгийн дүн	**18,090,389,403.61**	**18,090,389,403.61**
Богино хугацаат өр төлбөр	6,243,675,673.12	6,243,675,673.12
Нийт өр төлбөрийн дүн	6,243,675,673.12	6,243,675,673.12
Хувьцаат капиталын дүн	11,300,000,000.00	11,300,000,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	185,120,417.10	185,120,417.10
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	361,593,313.39	361,593,313.39
Эзэмшигчдийн өмч дүн	11,846,713,730.49	11,846,713,730.49
Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн дүн	**18,090,389,403.61**	**18,090,389,403.61**

2022 ОНЫ АУДИТАЛСАН ОРЛОГЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

"Хас хаан ББСБ" ХХК — 2022 оны 12 сарын 31

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд	Орлогын тайлангийн дүн 2022.12.31	Аудит хийгдсэн дүн 2022.12.31
Хүүгийн орлого	3,675,738,342.00	3,675,738,342.00
Хүүгийн бус орлого	5,385,860,714.81	5,385,860,714.81
Хүүгийн зардал	38,147,783.00	38,147,783.00
Боловсон хүчний холбогдолтой зардал	188,721,178.27	188,721,178.27
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	4,695,441,605.93	4,695,441,605.93
Үйл ажиллагааны бусад зардал	1,424,735,856.72	1,424,735,856.72
Зээлийн эрсдэлийн зардал	2,342,166,699.56	2,342,166,699.56
Орлогын албан татварын зардал	5,319,728.21	5,319,728.21
Үйл ажиллагааны бус орлого	54,535,815.27	54,535,815.27
Үйл ажиллагааны бус зардал	64,906,096.00	64,906,096.00
Татварын дараах цэвэр ашиг	**356,695,924.39**	**356,695,924.39**

"ФЛАШ АУДИТ" ХХК

2022 ОНЫ АУДИТАЛСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ ТАЙЛАН

"Хас хаан ББСБ" ХХК

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлтүүд	Санхүүгийн тайлангийн дүн 2022.12.31	Аудит хийгдсэн дүн 2022.12.31
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	810,516,247.48	810,516,247.48
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(64,906,096.00)	(64,906,096.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		

2022 ОНЫ АУДИТАЛСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн үзүүлэлтүүд	Санхүүгийн тайлангийн дүн 2022.12.31	Аудит хийгдсэн дүн 2022.12.31
Хувьцаат капитал	11,300,000,000.00	11,300,000,000.00
Бусад өмч	185,120,417.10	185,120,417.10
Хуримтлагдсан ашиг	361,593,313.39	361,593,313.39
Нийт эздийн өмч	**11,846,713,730.49**	**11,846,713,730.49**

АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад тус байгууллагын 2022 оны 12 сарын 31-ний байдлаархи баланс, орлогын тайлан, мөнгөн гүйлгээний болон өмчийн өөрчлөлтийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримт, холбогдох бусад материалуудыг хамруулж санхүүгийн тайлангийн тоо нь үнэн зөв гэдгийг баталгаажуулж, дүгнэлт өгөхөд аудитын зорилго оршино.

Бид санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү хянахдаа "Хас хаан ББСБ" ХХК-ийн дотоод хяналтын систем нь үр нөлөөтэй эсэх, санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас сэргийлэхийн тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыт тодруулах боломж олгосон.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Монгол төгрөгөөр тайлагнасан.

НИЙЦЛИЙН МЭДЭГДЭЛ

ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

"ФЛАШ АУДИТ" ХХК

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУРААНГУЙ ТОДРУУЛГА

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгө	2021.12.31	2022.12.31
Бэлэн мөнгө	31,143,795.49	30,942,469.22
Банкин дахь мөнгө	252,526,153.09	998,337,630.84
Нийт дүн	283,669,948.58	1,029,280,100.06

Банкин дахь 998,337,630.84 төгрөгийн үлдэгдэл нь банкны хяналтын хуулгаар баталгаажсан байна.

Зээл, зээлийн эрсдэл

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийг энэ дансанд тусгана. Зээл нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээлийн хүүний хувь хэмжээг Монгол банкны хүүгийн бодлого, ББСБ-ын активаас олох орлого болон пассивт төлөх төлбөрийн дундаж хувь хэмжээ, үйл ажиллагааны зардал зэрэгтэй уялдуулан 0.5-3.0 хувиар тогтоохоор зээлийн үйл ажиллагааг зохицуулах журамд заасан байна.

Зээлийн үндсэн эрсдэл нь зээл болон урьдчилгаагаар дамжин үүсдэг. Энэ тохиолдолд зээлийн эрсдэлтэй дүн нь баланс дахь хөрөнгийн дансны үнээр илэрхийлэгдэнэ.

• 2022 оны жилийн эцсийн байдлаар 10,807,419,462.82 төгрөгийн зээл нь хэвийн зээлд ангилагдсан байна.

• Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах нөөцийн түвшин дараах байдалтай байсан

	2022 он
Хугацаа хэтэрсэн зээл	5%
Хэвийн бус зээл	25%
Эргэлзээтэй зээл	50%
Муу зээл	100%

"ФЛАШ АУДИТ" ХХК

1. БАРАА МАТЕРИАЛ

ББСБ-ын бараа материалд үйл ажиллагаа явуулахад ашиглагдах бичиг хэрэг, хангамжийн материал орно.

2. ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД

ББСБ-ын санхүүгийн удирдлагын бодлого нь учирч болзошгүй сөрөг нөлөөг багасгахын тулд хүүний хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдэлүүдийг удирдахын зэрэгцээ ББСБ-ын хөгжлийг дэмжих санхүүгийн зохистой баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог.

a) Хүүний түвшний эрсдэл

Хүүний түвшний эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь зах зээл дээрх хүүний түвшний хэлбэлзэлтэй холбоотойгоор үүсдэг. ББСБ нь тогтмол хүүтэй харилцах дансны үлдэгдэлд авсан тогтмол хүү байдаг учраас хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэлд өртдөггүй.

b) Төлбөрийн чадварын эрсдэл

ББСБ нь зээлийн бүх эргэн төлөлт хэвийн гэдгийг баталгаажуулахын тулд өөрийн зээл олгосон гишүүдийн зарцуулалт болон барьцаа хөрөнгийг идэвхитэй хянаж байдаг. ББСБ нь өөрийн төлбөрийн чадварын зохистой байдлын ерөнхий удирдлагын нэг хэсэг болгон, өөрийн гишүүдийн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг бэлэн байлгадаг.

3. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нэг бүрийн бодит үнэ цэнийг ойролцоолон тооцоход (эдгээр үнэ цэнийг тооцох нь практик дээр боломжтой бол) дараах арга төсөөллүүдийг ашигладаг.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаат санхүүгийн хэрэглүүр учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

Холбоотой талуудад өгөх өглөг: Холбоотой талуудад өгөх өглөгүүд нь хугацаагүй буюу хүссэн үед нь төлөх нөхцөлтэй учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

4. КАПИТАЛЫН УДИРДЛАГА

ББСБ-ийн үндсэн зорилго нь хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг өсгөх явдал юм.

"ФЛАШ АУДИТ" ХХК

Үндсэн хөрөнгийн данс

		2021.12.31	2022.12.31
10.1	Барилга байгууламж	380,000,000.00	380,000,000.00
10.2	Хуримтлагдсан элэгдэл /Барилга байгууламж/	(83,721,916.43)	(98,911,928.46)
10.3	Эд хогшил	22,308,823.32	69,058,223.32
10.4	Хуримтлагдсан элэгдэл /Эд хогшил/	(13,848,945.88)	(30,325,618.82)
10.5	Техник хэрэгсэл	29,808,576.20	93,427,640.00
10.6	Хуримтлагдсан элэгдэл /Техник хэрэгсэл/	(11,111,145.97)	(46,589,536.88)

Бусад актив болон пассив

• Тайлант оны эцэст зээлийн хүүгийн авлага нь 1,488,835,295.10 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

• Богино хугацаат өрийн 6,243,675,673.12 төгрөгийн өглөг нь татварын өглөг багтсан байна.

ОРЛОГО

- Хүүгийн орлого

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Үндсэн зээл эсвэл хүү эргэн төлөгдөлт нь эргэлзээтэй болсон үед хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхийг хойшлуулдаг. Монгол банкны шаардлагын дагуу хүүгийн төлбөр нь 90 хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоодог. Хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоосон үед холбогдох хүүгийн авлагыг данснаас хасч балансын гадуур бүртгэдэг. Хүүг хүлээн зөвшөөрсөнийг зогсоосноос хойш хүүг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг. Эргэн төлөгдөх эргэлзээтэй байдал арилсан нөхцөлд хүүгийн орлогыг аккурэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

- Төлбөр хураамжийн орлого

Хэрэглэгчдэд үзүүлсэн санхүүгийн үйлчилгээндээ тэднээс төлбөр хураамж авдаг. Төлбөр хураамжийн орлогыг холбогдох үйлчилгээг үзүүлэх үед хүдээн зөвшөөрдөг

"ФЛАШ АУДИТ" ХХК

	2022.12.31
Орлогын нэр төрөл	
Хүүгийн орлого	3,675,738,342.00
Хүүгийн бус орлого	5,385,860,714.81
Үйл ажиллагааны бус зардал	64,906,096.00
Зардал	
Хүүгийн зардал	38,147,783.00
Боловсон хүчний холбогдолтой зардал	188,721,178.27
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	4,695,441,605.93
Үйл ажиллагааны бусад зардал	1,424,735,856.72
Зээлийн эрсдэлийн зардал	2,342,166,699.56
Орлогын албан татварын зардал	5,319,728.21

Тайлант онд хүүгийн болон хүүгийн бус орлогоор 9,116,134,872.08 төгрөг орж 1,613,457,034.99 төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардал, 2,342,166,699.56 төгрөгийг зээлийн эрсдэлийн зардал тооцож 356,695,924.39 төгрөгийн цэвэр ашигтай ажиллсан байна.

Тодруулга бэлтгэсэн:

Аудитор: /Ж.Зууннасан/

"ФЛАШ АУДИТ" ХХК